



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 10 сарын 23 өдөр

Дугаар A/82

Улаанбаатар хот

Г

Журам батлах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.3, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, 64.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмыг Захиргааны ерөнхий хуульд заасан хугацааны дотор Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, хянуулахыг Ажлын хэсэг /Я.Самбууням/-т, уг журмыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдэж хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Төрийн аудитын байгууллагын бүтцийн нэгжийн удирдлагад үүрэг болгосугай.
3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавин үр дүнг жил бүрийн дөрөвдүгээр улиралд багтаан танилцуулж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Д.Энхболд/-т даалгасугай.
4. Энэ тушаал мөрдөгдөж эхлэхтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/191, 2018 оны А/173 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Д.ЗАНДАНБАТ

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн
... дугаар тушаалын хавсралт

A/82

ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ДҮГНЭХ,
ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ЧАНАРЫГ ХЯНАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Үндэсний аудитын газар болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар (цаашид “Төрийн аудитын байгууллага” гэх) нь аудитад оролцуулах шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах харилцаанд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Төрийн аудитын байгууллагын аудитын үйл ажиллагаанд гэрээний үндсэн дээр оролцох шинжээч нь тухайн ажлыг гүйцэтгэх салбар, чиглэлээр мэргэшсэн, ажлын туршлага, хөндлөнгийн болон хараат бус байх шаардлагыг хангасан эрх бүхий хувь хүн, баг, хуулийн этгээд байх бөгөөд санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэх хуулийн этгээд нь Аудитын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан шаардлагыг хангасан байна.

1.3. Энэхүү журам нь Төрийн аудитын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Аудитын тухай хууль, Нягтлан бодох буртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн акт болон хавсралтаас бүрдэнэ.

1.4. Төрийн аудитын байгууллага нь аудитад дараах тохиолдолд шинжээчийг гэрээгээр ажиллуулна. Үүнд:

1.4.1. аудитад тодорхой асуудлаар лабораторийн болон бусад шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулах;

1.4.2. аудитад бодлогын болон нарийн мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж боловсруулах;

1.4.3. Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т заасны дагуу санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгүүлэх;

1.4.4. төрийн аудитын байгууллагын хүний нөөцийн хүчин чадлаас илүү гарсан ажлыг цаг хугацаанд нь гүйцэтгэх.

1.5. Шинжээчийн сонгон шалгаруулалтыг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан зохион байгуулах бөгөөд энэхүү журмын хүрээнд мэдээллийн технологи ашиглан зохион байгуулж болно.

1.6. Сонгон шалгаруулалтад оролцогчийн мэдээлэл, шинжээчийн гүйцэтгэсэн ажлын үнэлгээгээр Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т заасан мэдээллийн санг үүсгэх бөгөөд уг санг шинжээч сонгон шалгаруулах үйл ажиллагаанд ашиглаж болно.

1.7. Төрийн аудитын байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21¹ дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт заасан Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн эцсийн санхүүгийн тайланд хийх аудитыг аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх тохиолдолд захиалагч байх бөгөөд энэ журмын дагуу сонгон шалгаруулна.

1.8. Санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэсэн аудитын хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулахад Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7-д заасан журмыг мөрдөнө.

ХОЁР. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА БОЛОН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ

2.1. Төрийн аудитын байгууллагын бүтцийн нэгж нь тухайн жилд гүйцэтгэх аудитын болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан энэ журмын 1.4.3-т зааснаас бусад шинжээчийг аудитад оролцуулах саналыг төсвийн тооцооллын хамт жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газрын Тамгын газарт хүргүүлэх бөгөөд Тамгын газар төлөвлөгөө боловсруулан Монгол Улсын Ерөнхий аудитораар 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлуулна.

2.2. Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудит хариуцсан бүтцийн нэгж тухайн жилд төрийн аудитын байгууллагын хэмжээнд санхүүгийн тайлангийн аудитыг аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх шалгагдагч байгууллагын жагсаалт, ажлын багц болон холбогдох мэдээллийг жил бүрийн 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор боловсруулан танилцуулж, шалгагдагч байгууллагын болон багцын жагсаалтыг Монгол Улсын Ерөнхий аудитораар батлуулна.

2.3. Ажлын багцыг үүсгэхдээ өмчийн хэлбэр, аудитын цаглабар, эрсдэлийн үнэлгээ, аудитын үйлчилгээний төлбөр, газар зүйн байршил зэргийг харгалзан боловсруулна.

2.4. Үндэсний аудитын газар болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар энэ журмын 2.1, 2.2-т заасан шийдвэрийн дагуу шинжээч сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулна.

2.5. Шинжээчийн ажлын даалгаврыг захиалагч нэгж болон аудитын баг боловсруулан Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитораар батлуулан шинжээч сонгон шалгаруулах нэгж (хариуцсан ажилтан)-д хүргүүлнэ. Үндэсний аудитын газарт ажлын даалгаврын теслийг стратегийн удирдлага болон чанарын баталгаажуулалт хариуцсан нэгжээр хянуулсан байна.

2.6. Аудитын төрөл, хэлбэр, гэрээт ажлын онцлогоос шалтгаалан шинжээчид тавигдах тусгай шаардлагыг ажлын даалгаварт нарийвчлан тусгах бөгөөд дараах нийтлэг шаардлага тавигдана. Үүнд:

2.6.1. санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэх хуулийн этгээд нь аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй байх;

2.6.2. шинжээчээр ажиллах этгээд нь ажлын даалгаварт заасан мэргэжлийн чиглэлээр нарийн мэргэшсэн, эрдмийн зэрэг цолтой, тухайн ажлыг эрхлэх эрх бүхий байх;

2.6.3. тухайн салбарт ажилласан туршлагатай байх;

2.7. Шинжээчийг ажиллуулах хугацаа нь ажлын даалгаварт заасан ажлыг гүйцэтгүүлэхэд тохирсон байх бөгөөд аудитыг гүйцэтгэх хугацаанаас богино байна.

ГУРАВ. ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

3.1. Төсөвт өртөг нь 10 сая төгрөг хүртэлх ажлын шинжээч сонгон шалгаруулалтыг Үндэсний аудитын газар болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын худалдан авах ажиллагаа хариуцсан бүтцийн нэгж (хариуцсан ажилтан), 10 сая төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий ажлын шинжээчийг энэ журмын 3.2 дахь хэсэгт заасан ажлын хэсэг захиалагч нэгжээс ирүүлсэн ажлын даалгаврыг үндэслэн зохион байгуулна.

3.2. Шинжээч сонгон шалгаруулах ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий аудитор, аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын тэргүүлэх аудиторын тушаалаар захиалагч нэгжээс 2-оос дээшгүй төлөөлөл оролцуулан сондгой тоо бүхий 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

3.3. Шинжээч сонгон шалгаруулах ажлын хэсэг нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх бөгөөд ажлын хэсгийн гишүүн нь дараах шаардлага хангасан байна:

3.3.1. худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн байх;

3.3.2. тухайн салбарын иргэн, хуулийн этгээдтэй сүүлийн 3 жилийн хугацаанд хамаарал бүхий ажил үйлчилгээ эрхлээгүй байх.

3.4. Худалдан авах ажиллагаа хариуцсан бүтцийн нэгж (хариуцсан ажилтан) болон ажлын хэсэг дараах үе шатны дагуу шинжээчийг сонгон шалгаруулна:

3.4.1. Төсөөт өртөг нь 10 сая төгрөг хүртэлх ажлын шинжээч сонгон шалгаруулах:

3.4.1.1. шинжээч сонгон шалгаруулах тухай урилга (шинжээчид тавигдах шаардлага, ируулэх материал, хугацаа, төсөө бүхий)-ыг өдөр тутмын хэвлэл, байгууллагын цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.

3.4.1.2. оролцогч нь захиалагчийн зарлал болон урилгад дурдсан шаардлагын дагуу саналаа боловсруулах бөгөөд оролцох хүсэлт хүлээн авах хугацаа зар нийтэлснээс хойш 5 хоног байна. Уг хугацаа дуусмагц хүсэлт ирүүлсэн этгээдийн бүртгэлийг хөтөлж, баримтжуулна.

3.4.1.3. сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт ирүүлсэн этгээдийн материалыг ажлын 5 хоногийн дотор энэхүү журмын Хавсралт 1-т заасан Маят 3, 7, 8, 9-ийн дагуу үнэлж, дүнг Монгол Улсын Ерөнхий аудитор, аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын тэргүүлэх аудиторт танилцуулна.

3.4.1.4. сонгон шалгаруулалтаар “хамгийн сайн” үнэлэгдсэн этгээдэд шалгарсан болон бусад оролцогчид шалгараагүй үндэслэл, бусад шаардлагатай мэдээллийг албан бичгээр адил хугацаанд мэдэгдэнэ.

3.4.1.5. сонгон шалгаруулалтын дүнг мэдэгдсэнээс хойш Монгол Улсын Ерөнхий аудиторт гомдол гаргах хугацаа ажлын 3 хоног байх бөгөөд ирүүлсэн гомдлыг ажлын 5 хоногт шийдвэрлэж, хариуг хүргүүлнэ. Гомдол гаргах хугацаа өнгөрсөн эсхүл гомдлыг шийдвэрлэж, мэдэгдсэнээс хойш шалгарсан этгээдэд гэрээ байгуулах эрх олгоно.

3.4.2. Төсөөт өртөг нь 10 сая төгрөгөөс дээш ажлын шинжээч сонгон шалгаруулах:

3.4.2.1. ажлын хэсэг шинжээч сонгон шалгаруулах дэлгэрэнгүй жагсаалтад бүртгэх тухай зар (шинжээчид тавигдах шаардлага, материал ируулэх хугацаа, төсөө бүхий)-ыг өдөр тутмын хэвлэл, байгууллагын цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ. Дэлгэрэнгүй жагсаалтад бүртгэх хугацаа зар нийтэлснээс хойш 5 хоног байх бөгөөд хугацаа дуусмагц хүсэлт ирүүлсэн этгээдийн бүртгэлийг хөтөлж, баримтжуулна.

3.4.2.2. ажлын хэсэг материал ирүүлсэн этгээдийн нэрээр дэлгэрэнгүй жагсаалт үүсгэнэ.

3.4.2.3. дэлгэрэнгүй жагсаалтад бүртгэгдсэн этгээдийн ирүүлсэн материалыг энэ журмын Хавсралт 1-ийн Маят 3-ын дагуу 3 хоногийн дотор үнэлж, хураангуй жагсаалтыг үүсгэнэ.

3.4.2.4. хураангуй жагсаалтад бүртгэгдсэн этгээдэд саналын урилга болон ажлын даалгавар, холбогдох мэдээллийг хүргүүлэх бөгөөд урилга хүлээн авсан этгээд саналаа боловсруулж, 5 хоногийн дотор ирүүлнэ.

3.4.2.5. урилгын дагуу шинжээчээр ажиллах хүсэлт ирүүлсэн этгээдийн материалыг энэ журмын Хавсралт 1-ийн Маят 7, 8, 9-ийн дагуу 7 хоногийн дотор үнэлж, дүнг Монгол Улсын Ерөнхий аудитор, аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын тэргүүлэх аудиторт танилцуулна.

3.4.2.6. сонгон шалгаруулалтаар “хамгийн сайн” үнэлэгдсэн этгээдэд шалгарсан болон бусад оролцогчид шалгараагүй үндэслэл, бусад шаардлагатай мэдээллийг албан бичгээр адил хугацаанд мэдэгдэнэ.

3.4.2.7. сонгон шалгаруулалтын дүнг мэдэгдсэнээс хойш Монгол Улсын Ерөнхий аудиторт гомдол гаргах хугацаа ажлын 3 хоног байх бөгөөд ирүүлсэн гомдлыг ажлын 5 хоногт шийдвэрлэж, хариуг хүргүүлнэ. Гомдол гаргах хугацаа өнгөрсөн эсхүл гомдлыг шийдвэрлэж мэдэгдсэнээс хойш шалгарсан этгээдэд гэрээ байгуулах эрх олгоно.

ДӨРӨВ. ШИНЖЭЭЧТЭЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

4.1. Төрийн аудитын байгууллага сонгон шалгаруулалтаар “хамгийн сайн” үнэлгэдсэн этгээдэд гэрээ байгуулах тухай мэдэгдэл хүргүүлж, хэлэлцээр хийсний үндсэн дээр гэрээ байгуулна. Мэдэгдэл хүлээн авсан этгээд гэрээ байгуулахаас татгалзсан тохиолдолд дараагийн этгээдэд мэдэгдэл хүргүүлж гэрээ байгуулна.

4.2. Гэрээг захиалагчийг төлөөлж, Үндэсний аудитын газарт Монгол Улсын Ерөнхий аудитор, аймаг нийслэл дэх Төрийн аудитын газарт тэргүүлэх аудитор батална. Шинжээч болон шалгагдагч этгээдийг эрх бүхий этгээд төлөөлж, гэрээг батална.

4.3. Төрийн аудитын байгууллагаас шаардлагатай тохиолдолд аудитын ажлын зорилго, цар хүрээ, хэмжээ нь зохистой, хангалттай хэмжээнд тусгагдсан эсэхийг шалгаж, шинжээчтэй хэлэлцэн тохиролцож, ажлын даалгаварт нэмэлт тодруулга хийж болох бөгөөд энэ журмын 2.5-д заасан нэгжээр хянуулсан байна.

4.4. Шинжээчээр гүйцэтгүүлэх ажлын даалгавар болон тухайн шинжээчийн ирүүлсэн санал нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.5. Төсөвт өртөг нь 50 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил гүйцэтгүүлэх тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа шаардах бөгөөд энэ талаар урилгад тусгасан байна.

4.6. Төрийн аудитын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан төлөвлөгөөт бус аудит гүйцэтгэхэд шинжээч оролцуулах шаардлага гарсан болон нууцлал зэргээс хамааран энэ журмын 3.4 дэх хэсгийг баримтлахгүйгээр Монгол Улсын Ерөнхий аудиторын шийдвэрээр шаардлага хангасан этгээдэд санал хүргүүлж, гэрээ байгуулж болно.

4.7. Шинжээч сонгон шалгаруулалт нэг удаа амжилтгүй болсон тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудиторын шийдвэрээр шаардлага хангасан этгээдтэй гэрээ байгуулж болно.

ТАВ. ШИНЖЭЭЧИЙН ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ЧАНАРЫГ ХЯНАХ

5.1. Шинжээчийн ажлын гүйцэтгэл /явл/, тайлан (дүгнэлт) болон ажлын баримтад үе шатны хяналтыг захиалагчийн холбогдох албан тушаалтнууд хэрэгжүүлнэ.

5.2. Шинжээч нь гүйцэтгэж буй ажлын явцын болон эцсийн тайлан, дүгнэлт, ажлын баримтыг аудитын багт цаасан болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгч, үе шатны хяналт хийлгэнэ. Шаардлагатай тохиолдолд аудитын баг ажлын гүйцэтгэл, тайлан, дүгнэлтийн талаар дээд шатны албан тушаалтныг оролцуулан танилцуулга, сонсгол зохион байгуулж болно.

5.3. Шинжээч нь аудитын баг болон холбогдох албан тушаалтнаас цаасан болон цахим хэлбэрээр өгсөн санал, зөвлөмжийг хүлээн авч, тавьсан шаардлагыг хэрэгжүүлэх үүрэг хүлээх бөгөөд хүлээн зөвшөөрөгдсөн ажлын гүйцэтгэлийг захиалагчид гэрээнд заасан хугацаанд баталгаажуулж ирүүлнэ.

5.4. Шинжээч нь аудитын багаас өгсөн санал, зөвлөмжийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлээгүй эсхүл шинжээчийн ажлын гүйцэтгэл хангалтгүй, ажлын даалгаварт нийцээгүй болох нь нотлогдсон тохиолдолд аудитын багаас гэрээ цуцлах саналыг холбогдох баримтын хамт Монгол Улсын Ерөнхий аудитор, аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газарт Тэргүүлэх аудиторт танилцуулж, шийдвэрлүүлнэ.

5.5. Шинжээч нь гэрээт ажлыг гүйцэтгэхдээ ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд гэрээг цуцална.

5.6. Энэхүү журмын 5.4, 5.5-т заасан нехцэл үүсэж, гэрээ цуцлагдсан тохиолдолд шинжээч дахин ажиллуулж болох бөгөөд өмнө нь ажилласан шинжээчийг ажиллуулахгүй.

5.7. Шинжээчийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих албан тушаалтан нь ажлын гүйцэтгэл хангалттай, шаардлага хангасан тайлан, дүгнэлт, ажлын баримтыг хүлээн авах үүрэгтэй.

5.8. Шаардлагатай тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудиторын шийдвэрээр шинжээчийн гүйцэтгэсэн ажилд чанарын хяналт, магадлал хийлгэж болно.

ЗУРГАА. ШИНЖЭЭЧТЭЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭГ ДҮГНЭХ

6.1. Захиалагч нэгж, аудитын баг шинжээчийн ажлын гүйцэтгэлийг энэ журмын Хавсралт 2-т заасан маягтын дагуу дүгнэж, үнэлгээ өгөх бөгөөд шинжээчид танилцуулж, баримтжуулсан байна.

6.2. Шинжээчийн ажлын гүйцэтгэлийг нийт “100 оноо”-оор дүгнэх бөгөөд онооны үзүүлэлтээс хамаарч, дараах үнэлгээ өгөгднө.

6.2.1. 86-100 хүртэл оноо “Хангалттай”

6.2.2. 71-85 хүртэл оноо “Сайжуулах шаардлагатай”

6.2.3. 0-70 хүртэл оноо “Хангалтгүй”

6.3. Захиалагч нэгж шинжээчийн ажлын гүйцэтгэлийг үнэлж, гэрээг дүгнэсэн акт үйлдэн, тайлан, дүгнэлтийн хамт Үндэсний аудитын газрын Тамгын газар, аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудиторт тухай бүр хүргүүлэх бөгөөд гүйцэтгэлийн үнэлгээнээс хамаарч, гэрээнд заасны дагуу ажлын хөлсийг олгоно.

6.4. Шинжээч ажлын гүйцэтгэлийн үнэлгээ болон гэрээ дүгнэх актыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудиторт гомдол гаргах бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвэл хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлнэ.

ДОЛОО. БУСАД

7.1. Шинжээчийн гэрээт ажил нь “Хангалтгүй” үнэлэгдсэн, энэ журмын 5.4-д заасны дагуу гэрээ цуцлагдсан тохиолдолд Төрийн аудитын байгууллагаас 3 жилийн хугацаанд хамтран ажиллахгүй.

7.2. Шинжээч нь ёс зүйн зөрчил гаргасан, хараат бус байдлыг хангаж ажиллаагүй, төрийн болон албаны, хувь хүн, байгууллагын нууцыг задруулсан нь тогтоогдсон тохиолдолд төрийн аудитын байгууллагаас 5 жилийн хугацаанд хамтран ажиллахгүй бөгөөд тухайн асуудлыг шийдвэрлүүлэхээр эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүсэлт гаргана.

7.3. Шинжээчийн сонгон шалгаруулалтыг энэ журмын дагуу зохион байгуулаагүй, ажлын гүйцэтгэлийг үндэспэлгүйгээр буруу үнэлсэн болон шинжээчийн шаардлага хангаагүй тайлан, дүгнэлт, ажлын баримт хүлээн авсан нь тогтоогдвол холбогдох албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---ОоО---

**ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ,
ДҮГНЭХ, ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ЧАНАРЫГ ХЯНАХ ЖУРАМ
БОЛОВСРУУЛСАН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА**

2020 оны ¹⁰ дугаар сарын ²³ ...-ны өдөр

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2020 оны 05 дугаар сарын 01-нд батлагдсантай холбогдуулан тус хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т “Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчийг зохих журмын дагуу томилон ажиллуулж болно”, 17.6-д “Энэ хуулийн 17.1-д заасан шинжээчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална” гэж заасныг үндэслэн шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журмыг боловсруулан баталж, танилцуулж байна. Тус журам нь 7 зүйл, 42 хэсэг, 24 заалт, 5 хавсралтаас бүрдэнэ.

Журмын нэгдүгээр бүлэгт төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд шинжээч ажиллуулах нийтлэг үндэслэлийг, хоёрдугаар бүлэгт шинжээчид тавигдах ерөнхий шаардлага болон сонгон шалгаруулах үйл ажиллагааны төлөвлөлтийг, гуравдугаар бүлэгт шинжээч сонгон шалгаруулах үе шатыг, дөрөвдүгээр бүлэгт шинжээчтэй гэрээ байгуулах үе шатыг, тавдугаар бүлэгт шинжээчийн гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах үе шатыг, зургаадугаар бүлэгт шинжээчтэй байгуулсан гэрээг дүгнэх харилцааг, долоодугаар бүлэгт бусад асуудлыг тус тус зохицуулсан.

Тус журмыг шинэчлэн боловсруулахад дараах практик шаардлага тулгарч байна.
Үүнд:

- Шинжээч сонгон шалгаруулалтыг аудитын үйл ажиллагаатай уялдуулах;
- Шинжээчийг чанарт суурилсан үнэлгээгээр сонгон шалгаруулах;
- Шинжээчийн сонгон шалгаруулалтад ашиглах жишиг баримт бичиг, үнэлгээний маягт, ажлын даалгавар болон гэрээний загварыг байгууллагын онцлогт тохируулан боловсруулах.


Журам батлагдан гарснаар шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах үйл явц ил тод, тодорхой болох бөгөөд шинжээчид тавигдах ерөнхий шаардлага болон сонгон шалгаруулалтын үйл ажиллагааны төлөвлөлт, шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах, шинжээчтэй байгуулсан гэрээг дүгнэх харилцаа тус тус зохицуулагдана.

Мөн шинжээчийн ажлын гүйцэтгэлийг үндэслэлгүйгээр буруу үнэлсэн болон шинжээчийн шаардлага хангаагүй тайлан, дүгнэлт, ажлын баримт хүлээн авсан нь тогтоогдвол албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхээр журамд тусгасан.

Бид журмын төсөл боловсруулах, санал авах ажлыг Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагын дагуу гүйцэтгэсэн бөгөөд давхардсан тоогоор нийт 61 санал ирүүлснээс 38 саналыг хүлээж авах боломжгүй байсан бөгөөд 23 саналыг журмын төсөлд тусгасан болно.

— — _o0o_ — —

Монгол Улсын Ерөнхий аудиторын 20.. оны ... сарын ...-ны
өдрийн 18/20 тоот тушаалаар батлагдсан “Шинжээч сонгон
шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн
ажлын чанарыг хянах журам”ын 1 дүгээр хавсралт



ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХАД АШИГЛАХ МАЯГТУУД

- МАЯГТ 1- ШИНЖЭЭЧ СОНГОХ ЗАРЛАЛ
- МАЯГТ 2- ОРОЛЦОХ ХҮСЭЛТ ИРҮҮЛСЭН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ
- МАЯГТ 3- ШИНЖЭЭЧИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГЫГ ҮНЭЛЭХ ХҮСНЭГТ
- МАЯГТ 4- ХУРААНГУЙ ЖАГСААЛТАД БҮРТГЭГДСЭН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ
- МАЯГТ 5- ШИНЖЭЭЧ СОНГОХ УРИЛГА
- МАЯГТ 6- САНАЛ ИРҮҮЛСЭН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ
- МАЯГТ 7-АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ
- МАЯГТ 8-АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮДИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ
- МАЯГТ 9-АЖЛЫН ХЭСГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ

ШИНЖЭЭЧ СОНГОХ ЗАРЛАЛ

1. [Захиалагч байгууллагын нэр] нь [Аудитын нэр]-ийг гүйцэтгэх зорилгоор [гүйцэтгүүлэх ажлын нэр]-ийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулахаар төлөвлөж байгаа тул оролцох хүсэлтэй хувь хүн/баг/хуулийн этгээдийг мэдээллээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү шинжээч нь [ажлын төвч танилцуулга, байгууллага, хэрэгжүүлэх хугацаа, хамрах хүрээ гэх мэт] гүйцэтгэх болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй шинжээч нь дараах материалыг ирүүлнэ. Үүнд:
 - Хуулийн этгээдийн хувьд:
(Журмын гуравдугаар хавсралтын Маягт 3-ын хуулийн этгээд хэсгийг оруулах).
 - Баг, хувь хүний хувьд:
(Журмын гуравдугаар хавсралтын Маягт 3-ын баг/хувь хүн хэсгийг оруулах).
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг [огноо]-ний [цагийн] хооронд авч болох бөгөөд материалыа дор дурдсан хаягаар [санал хүлээн авах эцсийн огноо]-ний дотор цаасаар болон зөврийн диск-д цахим хэлбэрээр ирүүлнэ үү.

[Захиалагчийн тодорхой хаяг]

(өрөөний дугаар, харилцах албан тушаалтны нэр, утас/факс)

Тайлбар: Энэ маягтыг төсөөт өртөг нь 10 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй ажлын шинжээчийг сонгон шалгаруулахад дэлгэрэнгүй жагсаалт үүсгэхэд ашиглана.

**ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ,
ДҮГНЭХ, ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ЧАНАРЫГ ХЯНАХ ЖУРАМ
БОЛОВСРУУЛСАН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА**

2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2020 оны 05 дугаар сарын 01-нд батлагдсантай холбогдуулан тус хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т "Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчийг зохих журмын дагуу томилон ажиллуулж болно", 17.6-д "Энэ хуулийн 17.1-д заасан шинжээчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална" гэж заасныг үндэслэн шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журмыг боловсруулан баталж, танилцуулж байна. Тус журам нь 7 зүйл, 42 хэсэг, 23 заалт, 5 хавсралтаас бүрдэнэ.

Журмын нэгдүгээр бүлэгт төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд шинжээч ажиллуулах нийтлэг үндэслэлийг, хоёрдугаар бүлэгт шинжээчид тавигдах ерөнхий шаардлага болон сонгон шалгаруулах үйл ажиллагааны төлөвлөлтийг, гуравдугаар бүлэгт шинжээч сонгон шалгаруулах үе шатыг, дөрөвдүгээр бүлэгт шинжээчтэй гэрээ байгуулах үе шатыг, тавдугаар бүлэгт шинжээчийн гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах үе шатыг, зургаадугаар бүлэгт шинжээчтэй байгуулсан гэрээг дүгнэх харилцааг, долоодугаар бүлэгт хариуцлагын талаарх асуудлыг тус тус зохицуулсан.

Тус журмыг шинэчлэн боловсруулахад дараах практик шаардлага тулгарч байна.
Үүнд:

- Шинжээч сонгон шалгаруулалтыг аудитын үйл ажиллагаатай уялдуулах;
- Шинжээчийг чанарт суурилсан үнэлгээгээр сонгон шалгаруулах;
- Шинжээчийн сонгон шалгаруулалтад ашиглах жишиг баримт бичиг, үнэлгээний маягт, ажлын даалгавар болон гэрээний загварыг байгууллагын онцлогт тохируулан боловсруулах.

Журам батлагдан гарснаар шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах үйл явц ил тод, тодорхой болох бөгөөд шинжээчид тавигдах ерөнхий шаардлага болон сонгон шалгаруулалтын үйл ажиллагааны төлөвлөлт, шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах, шинжээчтэй байгуулсан гэрээг дүгнэх харилцаа тус тус зохицуулагдана.

Мөн шинжээчийн ажлын гүйцэтгэлийг үндэслэлгүйгээр буруу үнэлсэн болон шинжээчийн шаардлага хангаагүй тайлан, дүгнэлт, ажлын баримт хүлээн авсан нь тогтоогдвол албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхээр журамд тусгасан.

Бид журмын төсөл боловсруулах, санал авах ажлыг Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагын дагуу гүйцэтгэсэн бөгөөд давхардсан тоогоор нийт 61 санал ирүүлснээс 38 саналыг хүлээж авах боломжгүй байсан бөгөөд 23 саналыг журмын төсөлд тусгасан болно.

— — o0o — —

ОРОЛЦОХ ХҮСЭЛТ ИРҮҮЛСЭН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТ

Ажлын нэр:
Төсөвт өртөг:

Саналыг оны ... дугаар сарын ... -ны өдрийн ... цагт хүлээн авч, дор дурдсан мэдээллийг зарлаж тэмдэглэв.

| № | Нэр | Огноо | Бусад мэдээлэл |
|---------|-----|-------|----------------|
| 1 | | | |
| 2 | | | |
| ГЭХ МЭТ | | | |

| № | Асуудал үүсэж шийдсэн тухай ¹ |
|---------|--|
| 1 | |
| 2 | |
| ГЭХ МЭТ | |

Шинжээчийн төлөөлөгч

| № | Нэрс | Регистрийн дугаар | Гарын үсэг | Утасны дугаар |
|---------|------|-------------------|------------|---------------|
| 1 | | | | |
| 2 | | | | |
| ГЭХ МЭТ | | | | |

Ажлын хэсгийн ахлагч: /

Гишүүн: /

Гишүүн: /

Гишүүн: /

Нарийн бичгийн дарга /

¹ сонгон шалгаруулалтад оролцогч саналаа буцаах гэх мэт санал хүлээн авахад үүссэн ямарваа нэгэн асуудлыг тэмдэглэнэ.

ШИНЖЭЭЧИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГЫГ ҮНЭЛЭХ МАЯГТ

Шинжээчийн нэр:

| № | Шаардагдах материал ¹ | Ирүүлсэн эсэх | | Тайлбар |
|------------------------|--|---------------|------|---------|
| | | Тийм | Үгүй | |
| Хуулийн этгээд: | | | | |
| 1.1 | Улсын буртгэлийн гэрчилгээний хуулбар | | | |
| 1.2 | Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар | | | |
| 1.3 | Татварын тодорхойлолт /цахим/ | | | |
| 1.4 | Нийгмийн даатгалын тодорхойлолт /цахим/ | | | |
| 1.5 | ШШГЕГ-ын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй талаарх тодорхойлолт | | | |
| 1.6 | Шүүхийн төрөлжсен архивын тодорхойлолт | | | |
| 1.7 | ММНБИ-ын тодорхойлолт ² | | | |
| 1.8 | Гүйцэтгэсэн адил төсөөтэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/ | | | |
| 1.9 | Үндсэн ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар | | | |
| 1.10 | Үндсэн ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/ | | | |
| 1.11 | Санхүүгийн тайлан /сүүлийн 2 жилээр/ | | | |
| Баг, хувь хүн: | | | | |
| 2.1 | Иргэний үнэмлэхийн хуулбар | | | |
| 2.2 | Анкет /CV/ | | | |
| 2.3 | Боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар | | | |
| 2.4 | Гүйцэтгэсэн адил төсөөтэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/ | | | |
| 2.5 | Багийн хувьд гишүүдийн хамтран ажиллах гэрээ /нотариатаар баталгаажуулсан/ | | | |
| 2.6 | | | | |

Ажлын хэсгийн ахлагч: /

Гишүүн: /

Гишүүн: /

Гишүүн: /

Нарийн бичгийн дарга /

¹ Шинжээчийн ажлын даалгавраас хамаарч ирүүлэх материалын жагсаалтад өөрчлөлт орж болно.

² Шаардлагатай тохиолдолд аудитын хуулийн этгээдэд хамаарна.

ХУРААНГУЙ ЖАГСААЛТАД БҮРТГЭГДСЭН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ*/огноо/*

| № | Шинжээчийн нэр | Регистрийн дугаар | Хаяг, холбоо барих утас |
|---|----------------|-------------------|-------------------------|
| 1 | | | |
| 2 | | | |
| 3 | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

Ажлын хэсгийн ахлагч: /...../.....

Гишүүн: /...../.....

Гишүүн: /...../.....

Гишүүн: /...../.....

Нарийн бичгийн дарга /...../.....

ШИНЖЭЭЧ СОНГОХ УРИЛГА

/Огноо/

1. [Захиалагч байгууллагын нэр] нь [Аудитын нэр]-ийг гүйцэтгэх зорилгоор [гүйцэтгүүлэх ажлын нэр]-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах гэж байгаа тул дараах хувь хүн/баг/хуулийн этгээдийг саналаа ирүүлэхийг урьж байна.

1. Шинжээчийн сонгох урилга нь дараах бүрдэл хэсгүүдтэй байна. Үүнд:

Бүлэг 1 - Урилга
 Бүлэг 2 - Ажлын даалгавар
 Бүлэг 3 - Саналын жишиг баримт бичиг
 Бүлэг 4 - Гэрээний ерөнхий, тусгай нөхцөл
 Бүлэг 5 - Баталгаа /Хэрэв шаардсан бол/

2. Оролцох хүсэлтэй шинжээч нь саналын жишиг баримт бичгийг төгрөгөөр /бэлнээр/дансаар/ эргэн төлөгдөхгүй нөхцөлөөр худалдан авна/авахгүй.
3. Саналын жишиг баримт бичгийг Үндэсний аудитын газар/Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын хаягаас ирж авна.
4. Нэмэлт мэдээллийг авах хүсэлтийг санал ирүүлэх хугацаанаас ажлын 2 хоногийн өмнө албан бичгээр ирүүлнэ.
5. Саналаа битүүмжлэн дор дурдсан хаягаар [мэдүүлэг хүлээн авах эцсийн огноо, цаг]-ны дотор цаасаар болон зөөврийн диск-д цахим хэлбэрээр ирүүлнэ үү.

[Захиалагчийн тодорхой хаяг]

(өрөөний дугаар, харилцах албан тушаалтны нэр, утас/факс)

Тайлбар: Энэ маягтыг төсөөт өртөг нь 10 сая төгрөгөөс доош үнийн дүнтэй ажлын болон төсөөт өртөг нь 10 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй ажлын шинжээчийн хураангуй жагсаалтад бүртгэгдсэн этгээдийг сонгон шалгаруулахад ашиглана.

САНАЛ ИРҮҮЛСЭН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТ

Ажлын нэр:
Төсөвт өртөг:

Саналыг..... оны дугаар сарын-ны өдрийн ... цагт хүлээн авч, дор дурдсан мэдээллийг зарлаж тэмдэглэв.

| № | Нэр | Огноо | Бусад мэдээлэл |
|---------|-----|-------|----------------|
| 1 | | | |
| 2 | | | |
| гэх мэт | | | |

| № | Асуудал үүсэж шийдсэн тухай ³ |
|---------|--|
| 1 | |
| 2 | |
| гэх мэт | |

Оролцогчийн төлөөлөгч

| № | Нэрс | Регистрийн дугаар | Гарын үсэг | Утасны дугаар |
|---------|------|-------------------|------------|---------------|
| 1 | | | | |
| 2 | | | | |
| гэх мэт | | | | |

Ажлын хэсгийн ахлагч: /

Гишүүн: /

Гишүүн: /

Гишүүн: /

Нарийн бичгийн дарга /

³ сонгон шалгаруулалтад оролцогч саналаа буцаах гэх мэт санал хүлээн авахад үүссэн ямарваа нэгэн асуудлыг тэмдэглэнэ.

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ

/Огноо/

Ажлын нэр:

| № | Үзүүлэлт | Авч болох дээд оноо | Оролцогчийн нэр | | | | |
|------------------|---|---------------------|-----------------|------|------|------|------|
| | | | | | | | |
| 1 | Туршлага | 30 | | | | | |
| 1.1 | Гүйцэтгэсэн адил төсөөтэй ажил | 25 | | | | | |
| 1.2 | Ажил гүйцэтгэхэд шаардагдах ажлын байр, тоног төхөөрөмж гэх мэт | 5 | | | | | |
| 2 | Ажил гүйцэтгэх хөтөлбөр, аргачлал | 20 | | | | | |
| 2.1 | Ажил гүйцэтгэх хөтөлбөр | 10 | | | | | |
| 2.2 | Ажиллах хүчний ажлын хуваарь | 5 | | | | | |
| 2.3 | Аргачлал | 5 | | | | | |
| 3 | Голлох ажилтнууд | 40 | | | | | |
| 3.1 | Хүний нөөц | 20 (15) | | | | | |
| 3.2 | Боловсрол, мэргэшлийн зэрэг | 20 | | | | | |
| 3.3 ⁴ | | (5) | | | | | |
| 4 | Саналын иж бүрдэл | 10 | | | | | |
| | Бүгд | 100 | | | | | |

Ажлын хэсгийн гишүүн: / /

⁴ Захиалагч нэгжийн саналыг үндэслэн үнэлгээний үзүүлэлт нэмж оруулж болох бөгөөд ажлын хэсэг шийдвэрлэнэ. Үнэлгээний үзүүлэлт нэмэгдсэн тохиолдолд 3.1-ийг "15" оноогоор үнэлнэ.

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮДИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ

/Огноо/

Оролцогчийн нэр:

| № | Үзүүлэлт | Ажлын хэсгийн гишүүдийн нэр | | | | | Дундаж оноо |
|------------------|---|-----------------------------|------|------|------|------|----------------|
| | | | | | | | |
| 1 | Туршлага | | | | | | |
| 1.1 | Гүйцэтгэсэн адил төсөөтэй ажил гүйцэтгэсэн | | | | | | |
| 1.2 | Ажил гүйцэтгэхэд шаардагдах ажлын байр, тоног төхөөрөмж гэх мэт | | | | | | |
| 2 | Ажил гүйцэтгэх хөтөлбөр, аргачлал | | | | | | |
| 2.1 | Ажил гүйцэтгэх хөтөлбөр | | | | | | |
| 2.2 | Ажиллах хүчний ажлын хуваарь | | | | | | |
| 2.3 | Аргачлал | | | | | | |
| 3 | Голлох ажилтнууд | | | | | | |
| 3.1 | Хүний нөөц | | | | | | |
| 3.2 | Боловсрол, мэргэшлийн зэрэг | | | | | | |
| 3.3 ⁵ | | | | | | | |
| 4 | Саналын иж бүрдэл | | | | | | |
| | Бүгд | | | | | | |

Ажлын хэсгийн ахлагч: /

Гишүүн: /

Гишүүн: /

Гишүүн: /

Нарийн бичгийн дарга /

⁵ Захиалагч нэгжийн саналыг үндэслэн нарийвчилсан шаардлагыг оруулж болох бөгөөд ажлын хэсэг шийдвэрлэнэ.

АЖЛЫН ХЭСГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ

/Огноо/

Ажлын нэр:

| № | Үзүүлэлт | Шинжээчийн нэр | | | | |
|---|-----------------------------------|----------------|------|------|------|------|
| | | | | | | |
| 1 | Туршлага | | | | | |
| 2 | Ажил гүйцэтгэх хөтөлбөр, аргачлал | | | | | |
| 3 | Голлох ажилтнууд | | | | | |
| 4 | Саналын иж бүрдэл | | | | | |
| | Нийт оноо | | | | | |
| | Эзэлсэн байр | | | | | |

Ажлын хэсгийн ахлагч: /

Гишүүн: /

Гишүүн: /

Гишүүн: /

Нарийн бичгийн дарга /

Монгол Улсын Ерөнхий аудиторын 20²⁰ оны 10²⁰ сарын 28-ны
өдрийн 9/28 тоот тушаалаар батлагдсан "Шинжээч сонгон
шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, түйцэтгэсэн
ажлын чанарыг хянах журам"-ын 2 дугаар хавсралт

ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МЯГТ

| Ажлын гүйцэтгэл / явц-/ийн үнэлгээ /60/ | | Тайллан (дүгнэлт), ажлын баримтын үнэлгээ /40/ | |
|---|--|--|--|
| Тавигдах шаардлага, че шатны хяналт | | Gyphən xəparkylıçcah rəqəəhəA səaccəhə aktpıbr Aktıbhı Azzarabap, | |
| Авбал зохих дээд оноо | | Dyphən xəparkylıçcah rəqəəhəA səaccəhə aktpıbr Aktıbhı Azzarabap, | |
| Аудитор, ахлах аудитор | | Dyphən xəparkylıçcah rəqəəhəA səaccəhə aktpıbr Aktıbhı Azzarabap, | |
| Аудитын менежер | | Dyphən xəparkylıçcah rəqəəhəA səaccəhə aktpıbr Aktıbhı Azzarabap, | |
| Газрын захирап/дарга | | Dyphən xəparkylıçcah rəqəəhəA səaccəhə aktpıbr Aktıbhı Azzarabap, | |
| МҮЕА-ын орлогч | | Dyphən xəparkylıçcah rəqəəhəA səaccəhə aktpıbr Aktıbhı Azzarabap, | |
| Дундаж үнэлгээ | | Dyphən xəparkylıçcah rəqəəhəA səaccəhə aktpıbr Aktıbhı Azzarabap, | |
| НИЙТ ҮНЭЛГЭЭ | | оноо буюу " | |
| 5 | | 5 | |
| 10 | | 10 | |
| 5 | | 10 | |
| 30 | | 10 | |
| Аббал зохих шаардлага, че шатны хяналт | | Gyphən xəparkylıçcah rəqəəhəA səaccəhə aktpıbr Aktıbhı Azzarabap, | |

Үнэлгээний танилцаж, зөвшөөрсөн:

Шинжээч /

Үнэлгээ өгсөн:

МҮЕА-ын орлогч /

Газрын захирап/дарга /

Аудитын менежер /

Аудитор, Ахлах аудитор /

Тайлбар: Ажлын явцын болон гүйцэтгэлийн хяналтад энэхүү маягтыг ашиглана. Аудитын төрөл, хэлбэрээс хамаарч үзүүлгээний үзүүлэлтэд
нэмэлт оруулж болно.

БАТЛАВ:
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР
Д.ЗАНДАНБАТ

2020 оны 10 дугаар сарын 23.-ний өдөр

**ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ДҮГНЭХ,
ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ЧАНАРЫГ ХЯНАХ ЖУРАМ БОЛОВСРУУЛАХ ЯВЦАД
ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ**

Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д заасны дагуу “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ын төслийг боловсруулж, төсөлд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/147 дугаар тушаалаар баталсан “Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу дараах байдлаар нөлөөллийн шинжилгээ хийснийг танилцуулж байна. Үүнд:

1. Журмын үндэслэл, шаардлага, зорилт;

Хууль зүйн үндэслэл:

Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.1 ‘Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчийг зохих журмын дагуу томилон ажиллуулж болно”, 17.6-д “Энэ хуулийн 17.1-д заасан шинжээчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална” гэж заасныг үндэслэн шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журмыг боловсрууллаа.

Практик шаардлага:

- Шинжээч сонгон шалгаруулалтыг аудитын үйл ажиллагаатай уялдуулах;
- Шинжээчийг чанарт суурилсан үнэлгээгээр сонгон шалгаруулах;
- Шинжээчийн сонгон шалгаруулалтад ашиглах жишиг баримт бичиг, үнэлгээний маягт, ажлын даалгавар болон гэрээний загварыг байгууллагын онцлогт тохируулан боловсруулах.

Зохицуулах харилцааны зорилт:

Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан хэрэгжилтийг хангах, шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах үйл явц ил тод, тодорхой болоход чиглэнэ.

2. Журмын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ;

Тус журмыг Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2020 оны 05 дугаар сарын 01-нд батлагдсантай холбогдуулан дээр дурдсан үндэслэл шаардлагын хүрээнд боловсруулсан.

Ерөнхий бүтэц:

Тус журам нь 7 бүлэгтэй.

Нэгдүгээр бүлэгт: Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд шинжээч ажиллуулах нийтлэг үндэслэл;

Хоёрдугаар бүлэгт: Шинжээчид тавигдах ерөнхий шаардлага болон сонгон шалгаруулах үйл ажиллагааны төлөвлөлт;

Гуравдугаар бүлэгт: Шинжээч сонгон шалгаруулах;

Дөрөвдүгээр бүлэгт: Шинжээчтэй гэрээ байгуулах үе шат;

Таедугаар бүлэгт: Шинжээчийн гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах;

Зургаадугаар бүлэгт: Шинжээчтэй байгуулсан гэрээг дүгнэх;

Долоодугаар бүлэгт: Бусад асуудлыг тус тус зохицуулсан.

Зохицуулах харилцаа:

Энэ журмаар Шинжээчид тавигдах ерөнхий шаардлага болон сонгон шалгаруулалтын үйл ажиллагааны төлөвлөлт, Шинжээч сонгон шалгаруулах, Шинжээчтэй гэрээ байгуулах, Шинжээчийн гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах, Шинжээчтэй байгуулсан гэрээг дүгнэх харилцааг тус тус зохицуулна.

Мөн Шинжээчийн ажлын гүйцэтгэлийг үндэслэлгүйгээр буруу үнэлсэн болон шинжээчийн шаардлага хангаагүй тайлан, дүгнэлт, ажлын баримт хүлээн авсан нь тогтоогдвол албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхээр журамд тусгасан.

Хамрах хүрээ:

Журмын үйлчлэх хүрээ нь Төрийн аудитын байгууллага Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.6-д заасны дагуу аудитын үйл ажиллагаанд шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах ажиллагаанд үйлчилнэ.

3. Журмаар бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөх бүлгийг тодорхойлох;

Журам батлагдсанаар бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдгаар хөндөгдөх бүлэг байхгүй болно.

4. Журамд хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх;

| № | Холбогдох асуултууд | Хариулт |
|----------|--|----------------|
| 1. | Ялгаварлан гадуурхсан эсхүл аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх | Үгүй |
| 2. | Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулж байгаа эсэх | Үгүй |
| 3. | Жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх | Тийм |
| 4. | Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нелөө үзүүлэх эсэх | Үгүй |
| 5. | Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдөл бий болох эсэх | Үгүй |
| 6. | Аль нэг аж ахуйн нэгжид, ялангуяа зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэл бий болох эсэх | Үгүй |
| 7. | Төрийн байгууллага болон бусад иргэн, хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт ачаалал бий болох эсэх | Үгүй |
| 8. | Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсооход хүргэх эсэх | Үгүй |
| 9. | Эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд ямар нэгэн саад хориг тогтоох эсэх | Үгүй |
| 10. | Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх | Үгүй |
| 11. | Хүнд суртал, авлига гарах нөхцөл, боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт байгаа эсэх | Үгүй |

5. Тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх;

Асуудлыг зохицуулж буй хууль:

- Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

Хэм хэмжээний акт:

- Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/191 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”

- Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/173 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”

6. Журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо

Аудитын үйл ажиллагаанд шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, гэрээг дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шинээр хүний нөөцийн болон эдийн засгийн зардал шаардагдахгүй бөгөөд журмыг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэн, хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсэхгүй болно.

7. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/147 дугаар тушаалаар баталсан “Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-ын 2.4 дэх заалтыг хэрэгжүүлсэн эсэх

Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт “Захиргааны хэм хэмжээний актын төслийг тухайн захиргааны байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт 30-аас доошгүй хоногийн хугацаанд байрлуулж санал авна” гэж заасны дагуу Үндэсний аудитын газрын www.audit.mn цахим хуудсанд 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдөр байршуулж, олон нийтэд танилцуулж, саналыг авч нэгтгэсэн.

_____o0o_____